



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/858

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “в”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дугаар зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/10 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн ажиллах үеийн хоол, байрны зардал болох 1 000 000 төгрөг /Нэг сая/-ийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 1 000 000 төгрөг / Нэг сая/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ